

Оюун ухаан болон сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан хоорондын холбоо хамаарлыг судалсан нь

Б.Энхбаяр^{*а}, П.Цэрэндондов^б

^аОтгонтэнгэр их сургууль, Сурган хүмүүжүүлэх сэтгэл судлалын тэнхим

^бМонгол Улсын Боловсролын Их Сургууль, Боловсрол судлалын сургууль

Хураангуй

Бидний судалгааны ажил нь оюутан бие хүний сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан, оюун ухаан хоорондын холбоо хамаарлыг илрүүлэхэд чиглэсэн. Ингэхдээ оюун ухаан болон сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны талаарх эрдэмтдийн үзэл баримтлалыг харьцуулан шинжилж, оюутнуудаас оюун ухаан болон сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааныг судлан үр дүн, холбоо хамаарлыг харьцуулан судалсан. Энэ нь оюутны амжилттай суралцах үйлийг дан ганц оюун ухааны үйл ажиллагааны хүрээгээр тодорхойлох нь учир дутагдалтай бөгөөд амжилттай суралцахад гол нөлөө үзүүлдэг сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны оролцоо, оюун ухаантай хэрхэн хамааралтай болохыг харьцуулан судаллаа. Судалгааны үр дүнгээс ажиглахад оюун ухаан, сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны хооронд шууд порпорцианаль хамаарал байхгүй болох нь ажиглагдаж байгаа бөгөөд оюутны сурах үйл ажиллагааг оюун ухаан, сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны үзүүлэлтийг хамтад нь дэмжин хөгжүүлэх, үнэлэх чиглэлд ажиллах нь чухал байна.

Түлхүүр үг

Өөрийн ухамсар, өөрийн удирдлага, эмпати, өөрийн сэдэлжүүлэлт, танин мэдэх үйл

Удиртгал

Сүүлийн жилүүдэд сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны (Emotional intelligence) талаарх судалгаа шинжилгээ ихэд хийгдэж байна. Энэ нь энэ сэдвийн эрэлт хэрэгцээ, практик ач холбогдол өндөр байгаагийн нэгэн илрэл юм. Ялангуяа Америк, Европын холбооны улсуудын эрдэмтэн судлаачид тус сэдвийг олон талаас нь судалж, судалгааны үр дүнг үйлдвэрлэл практикт өргөнөөр ашиглаж байна. Харин манай улсын хувьд төдийлөн их судлагдаагүй бөгөөд эрдэм шинжилгээний өгүүлэл, зарим нэг судалгааны төвүүдийн судалгааны тайлан, их дээд сургуулийн бакалавр, магистрын түвшинд судлагдаж байна. Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан нь ялангуяа боловсролын салбарт сургалтыг үр өгөөжтэй хэрэгжүүлэх, үр дүнг сайжруулахад гаднын улс орнуудад түгээмэл судлагдаж, хэрэглэгдэж буй сэдэв юм. Иймд оюутны сурлагын амжилтыг сайжруулахад дан ганц танин мэдэхүйн чадварыг бус сэтгэлийн хөдөлгөөний үзүүлэлтүүдийг дэмжин хөгжүүлэх хэрэгцээ шаардлага тулгарч байгаа юм. Мөн сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан нь оюун ухааны ерөнхий чадварын шууд нөлөөнд оршдог үзэгдэл биш болох талаар томоохон эрдэмтдийн байр суурь, амьдралын практик жишээнүүд нотолж байгаа мэдээ баримтууд ч байна. Ямартай ч эдгээрийн холбоо хамаарлыг судалгааны ажлаараа тодорхой хэмжээнд илрүүлэхийг

зорьсон. Судалгааны ажлын зорилго нь оюутны сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан болон оюун ухаан хоорондын холбоо хамаарлыг илрүүлэхэд чиглэх бөгөөд зорилгоо хэрэгжүүлэх үүднээс сэдэвтэй холбогдох ном зохиолыг тоймлон судлах, сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан болон оюун ухааны талаарх онол, үзэл баримтлал, загварыг харьцуулан шинжлэх, оюутны сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааныг бүрэлдэхүүн хэсгүүдээр нь харьцуулан дүн шинжилгээ хийх ажлуудыг хэрэгжүүлсэн.

Бид судалгааны ажлын явцад сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан нь бие даасан, цогц шинжтэй үзэгдэл бөгөөд сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан, оюун ухааныг харьцуулан шинжлэх замаар тэдгээрийн холбоо хамаарлыг илрүүлэх боломжтой гэж үзэж байгаа юм.

Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны талаарх үзэл баримтлал

Чарльз Дарвины⁷ 1872 оны зарим бүтээлүүдэд сэтгэлийн хөдөлгөөний болон нийгмийн оюун ухааны талаар амьдрах болон дасан зохицох үйлтэй холбон тайлбарласан алдартай эшлэл, үзэл баримтлалууд тусгагдсан байдаг. Тэрээр амьдралын төлөө тэмцэх хүний сэтгэлийн хөдөлгөөний үйл явц нь хүний оюун

^{*}Холбоо барих зохиогч: b.enkhbayar@otgontenger.edu.mn

⁷Charles Darwin, Chapin

ухааны үндэс суурь болохыг онцолж байв. Чарльз Дарвины "Хүн ба амьтдын сэтгэлийн хөдөлгөөн" (1872) бүтээл нь түүхийн хувьд сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны хөгжилд тэр дундаа биологи болон сэтгэлийн хөдөлгөөний холбоо хамаарлыг тодруулах асуудалд чухал хувь нэмэр оруулсан. Мөн Эдвард Торндайкийн⁸ "Бага насны хүүхдийн нийгмийн оюун ухааныг хэмжих нь" сэдэвт өгүүлэл нь энэхүү сэдвийн талаар 20-р зууны эхэн үед судалгаа хийгдэж байсныг нотолж байна (Торндайк, 1920, х.227-235) (Чэйпин, 1942, х.214-225). Тэрээр бусад хүмүүсийг ойлгох, удирдах чадвараар нийгмийн оюун ухааныг тодорхойлж байсан бөгөөд оюун ухааныг илэрхийлж байдаг хэд хэдэн төрлүүдийн нэг нь нийгмийн оюун ухаан хэмээн үзэж байсан. Энэ үед Дэвид Векслер хүний оюун ухааны ерөнхий чадварыг хэмжих үзүүлэлтүүдийг боловсруулж байсан бөгөөд тэрээр оюун ухааны ерөнхий чадварын хүрээнд хүний зан үйлийн үзүүлэлтийг бүрдэл хэмээн авч үзэх оролдлого хийж байсан. Өөрөөр хэлбэл, оюун ухааны болон оюун ухааны бус гэсэн хоёр элементийг зэрэгцүүлэн авч үзэж нэг нь нөгөөдөө харилцан нөлөөлдөг болохыг дурдсан байдаг. Тэрээр оюун ухааны бус чадварт хүний зан чанар талаас авч үзээд хувийн болоод нийгмийн хүчин зүйлийг тусгасан байна. Энэ нь тухайн хүний ирээдүйн амжилт ололт, хэрхэн амьдрахыг урьдчилан таамаглах боломжийг олгодог гэж үзжээ. 1939 онд Д.Векслер⁹ нь хүний оюун ухааныг хэмжих хоёр дэд хэсэг бүхий тестийг боловсруулсан байдаг (Векслер, 1940, х.444-445). Үүний адилаар Ховард Гарднер¹⁰ (1983) "Оюун ухааны хүрээ" бүтээлийг туурвисан байна. Үүндээ оюун ухааны бие даасан 7 хэв шинжид харилцааны чадварыг оруулсан нь мөн л оюун ухааны чадваруудтай хам авч үзэж буй хандлага юм. Тэрээр Interpersonal intelligence буюу бусадтай харилцах чадвар болон Intrapersonal intelligence буюу хувь хүний дотоод зохицуулалтыг авч үзсэн бөгөөд үүнд өөрийн болон бусдын сэтгэл санааны байдал, мэдрэмж, хүсэл эрмэлзлийг ойлгож мэдэх, айдас, урам зоригийг мэдрэх зэргийг онцолсон байдаг. Оюун ухааны уламжлалт үзэл баримтлалууд нь хүний гүйцэтгэл, үйл ажиллагааны чанарыг бүрэн гүйцэт тодорхойлоогүй нь түүнийг Interpersonal intelligence болон Intrapersonal intelligence чадваруудыг оюун ухааны бүрэлдэхүүнд оруулахад хүргэсэн гэж үзэж болох юм (Гарднер, 1989, х.18-20). Харин зарим судлаачид түүний үзэл баримтлалд шүүмжлэлтэй хандаж байсан нь "Хэрвээ оюун ухааныг ийм өргөн хүрээнд

⁸Edward Thorndike

⁹David Wechsler

¹⁰Howard Gardner

авч үзэж байгаа бол урлагийн, ёс зүйн гэх мэт олон томоохон талбарууд дурдагдаагүй орхисон" гэх ойлголт юм. Мөн түүний оюун ухааны талаарх 7 хэв шинжийг оюун ухааны гэхээсээ илүү тусгай авьяасын шинжтэй асуудал гэж Нэйсир¹¹ тэргүүтэй эрдэмтэд үздэг (Нэйсир, Боодоо, Бөүчард, Боекин, Броди, 1996, х.77-101). Судлаачид үзэхдээ хүний дасан зохицох чадвар болон харилцах чадварыг тодорхойлохын өмнө хүний нийгмийн оюун ухааныг үндсээр нь тодорхойлох нь зүйтэй юм гэдэг байр суурь энэ үед маш хүчтэй бий болж эхэлсэн. Харин сэтгэлийн хөдөлгөөний талаарх үзэл баримтлал нь сэтгэц ухамсрыг судлан шинжилж эхэлсэн цагаас эрдэмтдийн дунд яригдаж ирсэн сэдэв юм. Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны судалгааны талбарт Эдвард Торндайк, Дэвид Векслер, Х.Гарднер нарыг өнөөгийн сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны талаарх судалгаа шинжилгээ хийдэг эрдэмтдийн үндэс суурийг тавьсан гэж үзэж болох юм. 1986 онд В.Пэйни¹² "A Study of Emotion: Developing Emotional Intelligence; Self-Integration; Relating to Fear, Pain and Desire" сэдэвт судалгааны ажил бичсэн нь тус сэдвийн чиглэлээр анхдагч судалгаа болсон юм (Пэйн, 1986, х.203А). В.Пэйн нь Ж.Мэйр, Д.Карусо нараас даруй 4 жилийн өмнө сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны талаарх судалгааг хийж байсан. Харамсалтай нь түүнийг сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан гэх ойлголтын гол төлөөлөгчдийн эгнээнд тийм ч түгээмэл дурддаггүй. Түүний сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны талаарх үзэл баримтлал нь сэтгэлийн хөдөлгөөний зохицуулалт гэхээсээ нийгмийн сэтгэл хөдлөл, аливаад хандах хандлага руу гол анхаарлаа төвлөрүүлж байсан.

2000-аад оны үед сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааныг мэдрэлийн эс, төв мэдрэлийн тогтолцоонд тайлбарлаж, бодит нотолгоог олохыг хичээж байсан (Лэйн¹³, 1990, х.124-134). Энэ чиглэлд судлаач Ледугийн¹⁴ нээлт ололт маш чухал хувь нэмэр оруулсан гэж үздэг.

Ихэнх судлаачдын судалгааны үр дүнд сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан нь бараг бүхий л ажилд хэрэгтэй чухал чадамжуудын үндэс суурь нь болдог гэж үздэг.¹⁵ (Чернис, 2000, х.10)

Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны талаарх нэлээд нухацтай судалгаа хийсэн Ж.Майер, П.Салови Д.Карусо нар юм. Тэд сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааныг хүний

¹¹U. Neisser

¹²Vein Pane

¹³Albert Lane

¹⁴Josef Ledoux

¹⁵Kari Cherniss

чадвар талаас нь авч үздэг. Сэтгэлийн хөдөлгөөн болон оюуны өсөлтийг сэтгэлийн хөдөлгөөнийг таньж мэдэх, удирдах, зохицуулах чадварууд нь дэмжиж өгдөг. Онолын үүднээс тайлбарлавал оюун санаа, сэтгэлийн хөдөлгөөний хослол нь сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан юм гэж үзсэн¹⁶ (Мэйр, Салови, 1997, х.3-31). Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааныг эрдэмтэд тодорхойлохдоо чадвар эсвэл сэтгэл зүйн онцлог шинж гэсэн 2 ерөнхий хүрээгээр тодорхойлж байна. Д.Майер, П.Салови (1990) нар сэтгэлийн хөдөлгөөн гэх нэр томъёог бий болгож түүнийгээ “Амьдралын өдөр тутам дахь харилцааг удирдах, таньж мэдэх, ойлгох, ашиглах чадвар” гэсэн 4 чиглэлд авч үзэж байсан. 1997 онд “Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан нь оюун ухаан болон сэтгэлийн хөдөлгөөнийг дэмжихийн тулд сэтгэл хөдлөлөө зохицуулах, сэтгэл хөдлөл мэдэрэмжээ таньж мэдэх ойлгох чадварыг эзэмшсэн байх үнэн зөв үнэлэлт өгөх, сэтгэл хөдлөлөө илэрхийлж, мэдрэмжийг бий болгох үйл явц юм” гэж тодорхойлжээ (Мэйр, Салови, 1997, х.3-31). Энэхүү шинэчилсэн тодорхойлолтоос үзэхэд сэтгэлийн хөдөлгөөн, мэдрэмжийг таньж ойлгох, удирдахаас гадна түүнийг ашиглах, өөрийн сэдэлжүүлэлт, хүмүүс хоорондын харилцааны асуудлуудыг багтаасан бөгөөд оюун ухааны холбоо хамаарлыг тусгаж өгсөн байна. Үндсэндээ сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааныг сэтгэлийн хөдөлгөөний хүлээн авах, ойлгох, ашиглах, удирдах гэсэн 4 чиглэлд авч үзсэн байна. Д.Майер, П.Салови нар нь сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааныг уламжлалт оюун ухаантай тодорхой хэмжээнд хамааруулан авч үздэг бөгөөд сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааныг чадвар гэж үздэг. Мөн Д.Гоулмэн¹⁷ (Гоулмэн, 1995). Д.Майер, П.Салови (Бар-он, 2000, х.22-26) нарын үзэж байгаагаар сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан гэдэг нь “Өөрийн болон бусдын сэтгэлийн хөдөлгөөн мэдрэмжийг таньж мэдэх, ялгах, тэдгээр сэтгэлийн хөдөлгөөнийг удирдан жолоодох, бусдын зан үйл, бодлын талаарх мэдээллийг зөв ашиглах үйл явц” гэж үздэг. Мөн сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан нь гэр бүл, хамт олон, найз нөхөдтэй харилцах харилцааг үр дүнтэй удирдан зохицуулах, тайван аз жаргалтай, эрүүл харилцааг бий болгох боломжийг бүрдүүлж өгдөг гэж үзсэн байна. Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан болон оюун ухааны холбоо хамаарал

Өнгөрсөн цаг хугацаанд боловсролын үйл ажиллагаа, сурлагын амжилтыг оюун ухааны хэмжүүртэй адилтган авч үзэх хандлага бага

багаар өөрчлөгдөж байна (Батлер¹⁸, 2006, х.119-125). Өнөө үед мөн цаашдын хэтийн төлөвт оюун ухааны чадамжийг академик амжилтаар хэмжих баталгаагүй бөгөөд хүний амжилттай амьдрахад олон хүчин зүйл нөлөөтэйг судлаачид тогтоож байна. Танин мэдэхүйн оюун ухаанаас гадна, нийгмийн болон сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан гэх чухал ойлголтууд бий болж байна. Гэхдээ уламжлалт оюун ухааныг огт үгүйсгээгүй бөгөөд үүн дээр нэмэх нь ухаалаг зан байдал, сэтгэл зүйн үзүүлэлтүүдийг давхар тооцож сая оюун ухааны ач холбогдол жинхэнэ утгаараа бий болно гэж үзэж байна (Мэйр, 2000а, х.47-56). Мөн Д.Гоулмэний 2001 онд бичсэн "The Emotionally Intelligence Workplace" бүтээлд оюун ухаан бол хүний ямар ажил мэргэжлийг эзэмшиж чадах талаарх урьдчилсан таамаглалыг илэрхийлэх бол сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан нь тэрхүү ажлын мэргэжлээр амжилтад хүрч чадах эсэхийг тодорхойлно. Тиймээс оюун ухаан, сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан харилцан бие биеэ нөхөх чухал хүчин зүйлүүд юм гэж бичсэн байна. Мөн Д.Гоулмэн 1995 онд бичсэн “Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан” номдоо тэрээр сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан болон оюун ухааныг дараах байдлаар тодорхойлсон байна. Оюун ухаан болон сэтгэл хөдөлгөөний оюун ухаан нь эсрэг чадамжууд биш харин тусдаа бие даасан чадамжууд юм. Бид сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан өндөр байвал оюун ухааны үзүүлэлт доогуур эсвэл оюун ухааны чадвар өндөр байвал сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан доогуур байдаг гэсэн хандлага байдаг хэдий ч энэ нь төдийлөн хамааралтай хувьсагчид биш юм. Мөн энэхүү хоёр чадварыг илрүүлэх тест нь өөр хоорондоо маш ялгаатай. Судалгаанаас ажиглахад энэхүү хоёр хувьсагчийн хоорондын холбоо хамаарал нь өөртөө итгэх итгэл, мэдрэмж, зохион байгуулалтын мэдлэг, уян хатан байдал, багаар ажиллах чадвар зэрэг сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны үзүүлэлтүүд нь тодорхой асуудал шийдвэрлэх, үр дүнд хүрэхэд илүү нөлөөтэй болохыг тогтоосон байна. Мөн оюун ухаан, сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан хоорондын холбоо хамаарлыг тодруулах өөр нэгэн судалгааг Розет, Карарчи¹⁹ нар хийсэн байна. Уг судалгаагаар оюун ухаан, сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан нэг дор илрэх боловч манлайллын түвшинд ялгаатай болох нь ажиглагдсан. Өөрөөр хэлбэл оюун ухааны чадвар өндөртэй ч гэсэн удирдах албан тушаал хашихгүй байхад оюун ухааны чадвараас үл хамаараад сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны чадвар өндөртэй хүмүүс удирдах албан тушаал

¹⁶John Mayer, David Caruso, Peter Salovey

¹⁷Daniel Goleman

¹⁸Butler

¹⁹Rosete, Ciarrochi

хашиж байгаа нь элбэг байгаа үзүүлэлт гарсан байна (Рэпоситори²⁰, 2009).

Оюун ухааныг оюутны сурлагын амжилттай салшгүй холбоотой гэж үздэг. Харин сурлагын амжилтыг ерөнхий оюун ухааны үзүүлэлт, сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны тест, хувь хүний зан чанар, хүйс, нас, оршин буй газар зэрэг холбон тайлбарлах нь илүү үр дүнтэй (Рөүсандэр²¹, 2011, х.590-596) гэж үзсэн байна. Оюутны сурлагын амжилтыг дан ганц оюуны үйлээр хэмжих нь хангалтгүй юм гэж тэрээр өөрийн судалгааны ажилдаа онцолсон байна.

Оюун ухаан болон сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааныг тархины мэдрэлийн эсийн үйл ажиллагааны ялгаатай талуудтай холбон тодорхойлсон байдаг. Тархины зулайн болон өмнөдхэсгийн үйл ажиллагаа нь оюун ухаан болон сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны чиглэлд ач холбогдол өндөр байгааг олж тогтоосон. Ерөнхий оюун ухааны хоёр бүрэлдэхүүн хэсэг (талстад оюун ухаан болон боловсруулах хурд) сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны үйл ажиллагаанд чухал хувь нэмэр оруулж байгаа нь ажиглагдсан. Улмаар хэл ярианы төвийн гэмтэл нь сэтгэлийн хөдөлгөөний үйл ажиллагаанд үлэмж нөлөө үзүүлж байсан бол духны өмнөд хэсгийн гэмтэл нь боловсруулах хурдны үйл ажиллагаанд нөлөө үзүүлж буйг олж тогтоосон байна. Иймд оюун ухаан болон сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны үйл ажиллагаа их тархины тодорхой нэг хэсгүүдэд мэдрэлийн эсийн үйл ажиллагааны хувьд давхцалууд байдаг гэж үзэж байна.

Оюун ухаан, сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан нь өөр өөрийн гэсэн тодорхой үүрэгтэй, тархины мэдрэлийн үйл ажиллагааны түвшинд явагддаг, зарим үйл ажиллагаанд нэгдэн илэрч зарим тохиолдолд дангаар илрэх тохиолдлууд байдаг.

Судалгааны арга зүй

Бид оюутан бие хүний сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааныг судлахдаа оросын сэтгэл судлаач Д.В.Люсиний²² арга зүйг ашигласан. Энэхүү арга нь бие хүний сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааныг 5 дэд, 4 ерөнхий, нэгдсэн нэг үзүүлэлт буюу нийт 10 үзүүлэлтээр хэмжихэд чиглэгдсэн 46 асуулга бүхий судалгааны арга зүй юм. Судлуулагч нийт 46 асуулгаас өөрт тохирохыг дараах 4 хариултын хувилбараас сонгоно. Мөн бид оюутны сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааныг, оюун ухаантай харьцуулан судлах үүднээс оюутны оюун ухааны ерөнхий

чадамжийг судлах Р.Б.Кеттелийн²³ арга зүйг ашигласан. Энэхүү арга зүй нь хүний суурь оюун ухааныг үнэлэхэд зориулагдсан бөгөөд “Оюун ухааны соёлоос ангид тест” гэх бөгөөд хүний соёлын ялгаа, эзэмшсэн боловсролын түвшин, нийгмийн байдал зэргээс үл хамаарах тест юм. Тестийн энэхүү хувилбар нь практик түгээмэл хэрэглэгддэг бөгөөд нийт 4 дэд сорилтой. Дээрх хоёр арга зүйн үр дүнгийн корреляци хамаарлыг тодруулж, харьцуулан чанарын болон тоон дүн шинжилгээ хийсэн.

Судалгааны үр дүн

Д.В.Люсин нь хүний сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны хөгжлийн үзүүлэлтүүдийг тодорхой бүтэц, бүрэлдэхүүн хэсгүүдэд оруулан дараах хүснэгт 1-ийн дагуу авч үздэг.

Хүснэгт 1

Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны үзүүлэлтийн бүтэц

	МЭИ - Бие хүн хоорондын сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан	ВЭИ - Өөрийн сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан
ПЭ - Сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох	МП - Бусдын сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох	ВП - Өөрийн сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох
УЭ - Сэтгэлийн хөдөлгөөнийг удирдах	МУ - Бусдын сэтгэлийн хөдөлгөөнийг удирдах	ВУ - Өөрийн сэтгэлийн хөдөлгөөнийг удирдах ВЭ - Өөрийн сэтгэлийн хөдөлгөөнийг хянах
ОЭИ - Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан	МП, МУ, ВП, ВУ, ВЭ	

Одоо судлагдсан оюутны сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны үзүүлэлтүүдийг дээрх бүтэц, бүрдэл хэсгүүдийн дагуу авч үзэх болно. Эхлээд ерөнхий 4 чадварын тоон үзүүлэлтүүдийг авч үзье.

²⁰Repository

²¹Rosander

²²Lusin.D.W

²³Raymond Cattell

Хүснэгт 2

Оюутны сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан (Ерөнхий 4 үзүүлэлтээр)

	С у д . тоо	Min-Max	\bar{X}	m	σ	t	p
Бие хүн хоорондын сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан (МЭИ)	231	6.0-64.0	34.97	0.53	8.09	-1.59	.111
Өөрийн сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан (ВЭИ)	233	12.0-71.0	36.12	0.59	9.08		
Сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох чадвар (ПЭ)	234	12.0-52.0	34.05	0.43	6.62	-4.44	.000
Сэтгэлийн хөдөлгөөнийг удирдах чадвар (УЭ)	234	12.0-88.0	38.74	0.63	9.64		

Хүснэгт 2-оос ажиглахад оюутны өөрийн сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны хөгжлийн чадвар нь (ВЭИ) 36.12 буюу хүмүүс хоорондын сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны хөгжлийн чадвар (МЭИ) 34.97 оноотой байна. Энэ байдлыг ажиглахад оюутны өөрийн сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны хөгжлийн (ВЭИ) харьцангуй илүү хөгжсөн байж болох тоон үзүүлэлт харагдаж байгаа боловч хүснэгт 2-ын үнэн магадлалын коэффициент “t”= -1.59, статистик ач холбогдлын түвшин “P”>0.05-аас ажиглахад статистик ялгаа энэ хоёр үзүүлэлтийн хооронд байхгүй байна. Тэгээд ч энэ хоёр үзүүлэлт хөгжлийн түвшний хувьд харьцангуй доогуур түвшинд хөгжжээ. Эдгээр үзүүлэлт (МЭИ, ВЭИ) харьцангуй доогуур түвшинд хөгжжээ гэсэн дүгнэлт яагаад хийв гэх асуулт гарна. Учир нь сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны дээрх 4 үзүүлэлт тус бүрдээ 39-47 оноо авсан тохиолдолд дундаж, үүнээс доош оноотой бол доогуур Т үүнээс дээш оноотой бол өндөр түвшинд хөгжсөн гэж үзэх хэмжүүр бий, түүнд тулгуурласан болно.

Оюутны сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох чадвар (ПЭ) 34.05, сэтгэлийн хөдөлгөөнийг удирдах чадвар (УЭ) нь 38.74 оноотой байна. Үүнээс ажиглахад сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох чадвар нь удирдах чадвараасаа харьцангуй доогуур хөгжжээ. Сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох болон удирдах чадварын оноо хоорондоо ялгаатай болохыг хүснэгт 2-ын t коэффициент болон статистик ач холбогдлын түвшин “P” баганын дагуу ажиглахад тодорхой харагдаж байна. Сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох болон удирдах чадварын оноо нь ерөнхийдөө доогуур түвшинд хамаарч байна.

$\bar{X} \approx M_o \approx M_e$ нь тухайн судалж буй тоон үзүүлэлт бөгөөд сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны нэгэн төрлийн байх шинжийг хангах үзүүлэлтүүд юм.

Хүснэгт 3

Оюутны сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны ерөнхий 4 чадвар (МЭИ, ВЭИ, ПЭ, УЭ)-ын дундаж тоон үзүүлэлт буюу төвийн статистик хэмжигдэхүүн

	МЭИ	ВЭИ	ПЭ	УЭ	EIQLtotal
N Valid	232	233	234	234	233
Missing	2	1	0	0	1
Mean	34.94	36.12	34.05	38.74	68.94
Median	34.00	36.00	34.00	38.00	69.00
Moda	34.00	34.00	31.00	34.00	67.00

Мөн Analyze – Scale – Reliability – analyze программ ашиглаж оюутны сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны дээрх ерөнхий 4 чадварыг судалсан батламжууд буюу асуултууд хэрэг зэрэг найдварт чанартай болохыг тодорхойллоо. (хүснэгт-4)

Хүснэгт 4

Судалгааны найдварт чанар

Reliability statistics	
Cronbach's Alpha	N of items
.774	4

Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны ерөнхий 4 чадварыг судалсан бүлэг батламжуудын буюу асуултуудын хувьд найдварт чанарыг тодорхойлохдоо Cronbach's Alpha аргыг ашиглав. Хэрэв Cronbach's Alpha коэффициент нь 0,7 - оос их байх тохиолдолд найдвартай байна гэж үздэг. Бидний судалгааны хувьд энэ найдварт чанар 0.774 (дээрх хүснэгт) байгаа учир сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны ерөнхий 4 чадварыг судалсан Д.В.Люсины боловруулсан арга зүйн батламжууд найдварт чанар сайн байгааг харуулж байгаа бөгөөд батламжуудын хоорондын уялдаа холбоо сайн оюутны сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны дээрх ерөнхий 4 чадварыг судалж болохуйц асуултууд байна гэсэн үг юм.

Д.В.Люсины боловсруулсан арга зүйн дагуу бид оюутны сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны: Бусдын сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох (МП), Бусдын сэтгэлийн хөдөлгөөнийг удирдах (МУ), өөрийн сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох (ВП), өөрийн сэтгэлийн хөдөлгөөнийг удирдах (ВУ), өөрийн сэтгэлийн хөдөлгөөний гадаад илрэлийг хянах (ВЭ) зэрэг 5 дэд бүрэлдэхүүн чадварыг харьцуулсан шинжилгээ хийхийг зорилоо. (Хүснэгт-5)

Хүснэгт 5

Оюутны сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны 5 дэд бүрэлдэхүүн хэсгийн тоон үзүүлэлт

	С у д . тоо	Min-Max	\bar{X}	m	σ	t	P
Бусдын сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох (МП)	228	0.0-40.0	19.45	0.35	5.36	МП-МУ=5.47	.000
						МП-ВП=6.51	.000
Бусдын сэтгэлийн хөдөлгөөнийг удирдах (МУ)	233	0.0-37.0	15.85	0.27	4.21	МП-ВУ=10.85	.000
						МП-ВЭ=11.73	.000
Өөрийн сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох (ВП)	234	0.0-48.0	14.74	0.30	4.71	МУ-ВП=2.89	.005
						МУ-ВУ=9.48	.000
Өөрийн сэтгэлийн хөдөлгөөнийг удирдах (ВУ)	234	0.0-34.0	12.46	0.24	3.80	ВП-ВУ=7.07	.000
						МУ-ВЭ=9.39	.000
Өөрийн сэтгэлийн хөдөлгөөний гадаад илрэлийг хянах (ВЭ)	233	0.0-48.0	10.77	0.29	4.56	ВУ-ВЭ=5.6	.000
						ВП-ВЭ=10.06	.000

Хүснэгт-5 аас ажиглахад бусдын сэтгэлийн хөдөлгөөний ойлгох (МП) чадвар нь 19.45 буюу маш доогуур түвшинд байгаа бол бусдын сэтгэлийн хөдөлгөөний удирдах (МУ) чадварын оноо 15.85 өөрийн сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох (ВП) чадварын оноо 14.74, өөрийн сэтгэлийн хөдөлгөөнийг удирдах (ВУ) чадварын оноо 12.46 буюу доогуур түвшинд хамаарч харин өөрийн сэтгэлийн хөдөлгөөнийг хянах (ВЭ) чадварын оноо 10.77 буюу бусад 4 үзүүлэлтүүдийг бодвол харьцангуй доогуур байгаа хэдий ч түвшинчлэлийн хэмжүүрийн хувьд дундаж түвшинд байгаа юм. Үүнээс үзэхэд нийт судлуулагчдын хувьд Д.В.Люсины арга зүйн дагуу оюутны сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны 5 үзүүлэлт доогуур түвшинд байна.

Харин хүснэгт 5-ийн Min-Max баганын дагуу ажиглах юм бол хувь оюутан бүрийн сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны эдгээр чадвар янз бүрийн түвшинд хөгжсөн байж болохоор харагдаж байна. Оюутны сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны энэ 5 дэд бүрэлдэхүүн хэсгийн чадварууд харьцангуй өөр өөр түвшинд ялгаатай хөгжсөн байгааг тодруулах үүднээс Analyze – Compare Means – Paired – Sample T Test шалгуур программыг ашигласан үр дүнг хүснэгт - 2.21-ийн t, P баганын дагуу ажиглаж болно. Эдгээрийг тодруулан өөр хооронд нь хоёр, хоёроор нь харьцуулан шинжлэхэд $P < 0.01$ буюу бараг 99%-ийн статистик ач холбогдол бүхий

ялгаатай хөгжжээ гэсэн дүгнэлтэд хүргэж байна. (Хүснэгт-5) Оюутны сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны энэ 5 дэд бүрэлдэхүүн чадваруудыг дотор нь хөгжлийн түвшинг нь харгалзан эрэмбэлэн авч үзэх юм бол харьцангуй хамгийн өндөр түвшинд бусдын сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох чадвар (МП), 2-рт бусдын сэтгэлийн хөдөлгөөнийг удирдах чадвар (МУ), 3-рт өөрийн сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох чадвар (ВП), 4-рт өөрийн сэтгэлийн хөдөлгөөнийг удирдах чадвар (ВУ), 5-рт өөрийн сэтгэлийн хөдөлгөөний гадаад илрэлийг хянах чадвар (ВЭ) гэсэн эрэмбэ дараалал бүхий түвшинд хөгжжээ гэж үзэж болохоор байна. Үүнийг хүснэгт 5-ын \bar{X} баганы дагуу ажиглахад тодорхой байна.

Хүснэгт 6

Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны ерөнхий үзүүлэлт

	С у д . тоо	Min - Max	\bar{X}	m	σ
Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны ерөнхий чадвар (ОЭИ)	233	6 . 0 - 122.0	68.94	0.92	14.13

Д.В.Люсины арга зүйн дагуу оюутны сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны ерөнхий чадварын нэгдсэн оноог авч үзэх юм бол 81-ээс

дээш доош оноотой бол сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны хөгжлийн чадвар доогуур, 81-95 онооны хооронд бол дундаж, үүнээс дээш оноо авсан бол сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны чадварын хөгжил өндөр түвшинд хөгжжээ гэж үздэг. Энэ хэмжүүрийн дагуу судлагдсан оюутны сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны дундаж ($\bar{X}=68.94\pm 0.92$) оноог дүйцүүлэн ажиглахад хөгжлийн доогуур түвшинд хамрагдаж байна. Ийм учраас бид оюутны сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны хөгжлийн түвшин яагаад ийм доогуур байна, шалтгаан нь юу байж болох вэ? хэрхэн яаж хөгжүүлэх вэ? зэрэг асуултууд гарч ирлээ. Энэ бүгдэд ямар тайлбар өгөх вэ? гэсэн асуулт гарч байна.

Энэ үүднээс Д.В.Люсины үзэл баримтлалыг авч үзье. Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан нь нэг талаас тухайн субъектийн танин мэдэхүйн чадвар, нөгөө талаас түүний хувийн шинж чанарт ач холбогдол өгдөг. Тодруулбал, сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан нь 1.Сэтгэлийн хөдөлгөөнийг танин мэдэх чадвар – Энэ нь сэтгэлийн хөдөлгөөний талаарх мэдээллийг боловсруулах хурд, оновч, 2.Сэтгэлийн хөдөлгөөний талаарх төсөөлөл - Энэ нь өөрийн болон бусад хүмүүсийн талаарх мэдээллийн чухал эх булаг болох үнэт зүйл, 3.Сэтгэлийн хөдөлгөөний онцлог - Энэ нь сэтгэлийн хөдөлгөөний тогтвор хувьсал өөрчлөлт бүхий чанар, сэтгэлийн хөдөлгөөний талаарх мэдрэмж зэрэг нь сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаанд нөлөөлөх хүчин зүйлүүд гэж үздэг.

Ийм учраас сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны хөгжил доогуур түвшинд хамрагдсан оюутны сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны ерөнхий чадвар нь хангалтгүй хөгжсөн шалтгааныг дээрх хүчин зүйлүүдтэй холбон тайлбарлах шаардлагатай гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл оюутны сэтгэлийн хөдөлгөөний талаарх төсөөллийг хөгжүүлэх, сэтгэлийн хөдөлгөөний онцлогийг нарийвчлан судлах асуудалд илүү ач холбогдол өгөх шаардлага гарч ирлээ.

Дээр бид оюутны сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны үр дүнд дүн шинжилгээ хийсэн бол одоо оюутны сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан, оюун ухаан хоорондын холбоо хамааралд хийсэн дүн шинжилгээг авч үзье.

Зарим судлаачдын дунд сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан, оюун ухааны ерөнхий чадваруудыг хам авч үзэх, эсвэл эсрэгцүүлэх, нэг нь нөгөөгөөсөө хамааралтай, эсвэл хамааралгүй мэтээр тайлбарласан ухагдахуунууд судалгааны явцад багагүй тохиолдсон. Гэхдээ энэхүү хоёр ухагдахуун нь тодорхой үйл ажиллагаанд нэгдэн илэрч болох хэдий ч нэг нь нөгөөгөөсөө

шалтгаалсан шууд хамаарал байхгүй болохыг ихэнх эрдэмтэд, ялангуяа энэ чиглэлийн гол төлөөлөгчдийн нэг Д.Гуолмэн нар онцолж байна.

Бидний гол зорилго бол оюутны сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан, оюун ухааны ерөнхий чадвар зэрэг нь өөр хоорондоо ямар холбоо хамааралтай байна вэ? гэдгийг тодорхойлоход чиглэгдсэн болохыг дээр өгүүлсэн. Одоо зарим үр дүнг дараах хүснэгтийн дагуу авч үзье.

Хүснэгт 7

Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан, оюун ухаан хоорондын хамаарал

	EIQ	Оюун ухааны ерөнхий чадвар
EIQ	1.00	.052
Оюун ухааны ерөнхий чадвар	.052	1.00
N	233	234

EIQ (Emotional intelligence quotient буюу сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан) болон оюун ухаан хооронд хамааралгүй ($r=0.05$) гэсэн үзүүлэлт гарч байна. Энэ нь эдгээр хоёр хүчин зүйл нь хоорондоо хамааралгүй бөгөөд нэг нь нөгөөгөөсөө хамаарч илэрдэг хувьсагчид биш юм байна. Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан болон оюун ухаан хооронд ямар нэг холбоо хамаарал илрэхгүй байгаа нь энэ хоёр хувьсагч харилцан бие биедээ нөлөөлж эсвэл аль нэгийгээ дагаж өсөж буурдаг үйл явц биш гэдгийг харуулж байна. Өөрөөр хэлбэл сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан өндөр байх нь оюун ухаан өндөр эсвэл доогуур байх шалтгаан биш юм. Хэрвээ энэхүү хоёр үзүүлэлт нь хоорондоо хамааралтай бол сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны ач холбогдол төдийлөн өндөр байхааргүй байсан. Иймд оюутнууд сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааныг хөгжүүлэх шаардлагатай бөгөөд үүнийг сургалтын үйл ажиллагаагаар дамжуулан хөгжүүлэх нь чухал юм. Уламжлалт сургалтын зорилго нь хүний оюун ухааныг хөгжүүлэхэд чиглэсэн бөгөөд энэ нь нийгмээс тавьж буй тодорхой шаардлагуудыг хангахуйц бие хүнийг бэлтгэхэд учир дутагдалтай байна гэдгийг эрдэмтэд болон сургалтын практик нотлон харуулж байна.

Дүгнэлт

Бид оюутны сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны суурь онол, үзэл баримтлал, чиг хандлагуудыг тоймлон судалж улмаар сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааныг бүтэц, бүрэлдэхүүн

тус бүрээр судлан шинжилж, сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан, оюун ухааны хөгжлийн ерөнхий чадвар хоорондын холбоо хамаарлыг илрүүлэхийг зорьсон.

Бид энэхүү судалгааны үр дүнд дараах дүгнэлтэд хүрсэн болно.

1. Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан нь хувь хүн өөрийн сэтгэлийн хөдөлгөөн, мэдрэмжээ ухамсарлан таних, түүнийгээ удирдан жолоодох, мөн бусад хүмүүсийн сэтгэлийн хөдөлгөөнийг таньж мэдэх ухамсарлах, тэдний сэтгэл, мэдрэмжийг хуваалцах, тэдэнд нөлөөлөх, удирдах гэсэн үндсэн агуулгын хүрээгээр тодорхойлогдож байна. Улмаар хүний шийдвэр гаргах болон асуудал шийдвэрлэх чадвар, өөрөө өөрийгөө сэдэлжүүлэх, урам зоригтой байх, дасан зохицох, өөдрөг байх, харилцах чадвар, стрессээ удирдах зэрэг олон чухал сэтгэл зүйн асуудлууд сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны шууд удирдлагад оршиж байна.
2. Мөн сэтгэлийн хөдөлгөөнийг хүртэж хүлээн авах, сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох, таньж мэдэх, сэтгэлийн хөдөлгөөнийг өөрийн үйл ажиллагаандаа ашиглах хэрэглэх, сэтгэлийн хөдөлгөөнийг удирдах зохицуулах гэсэн 4 чиглэлийн хүрээнд ч тодорхойлогдох боломж байна. Онолын судалгааны ажлаас үзэхэд сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан бол бие даасан сэтгэл зүйн томоохон бүрэлдэхүүн бөгөөд чадвар, сэтгэл зүйн онцлог, хувь хүний хандлага зэрэг аль алиныг өөртөө багтаасан цогц шинж чанар бүхий асуудал юм гэж бид үзлээ.
3. Бидний судалгаанд хамрагдсан оюутны сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан дундаж болон дунджаас доогуур түвшинд хөгжжээ. Ялангуяа тэдний өөрийн удирдлага, бусдын сэтгэлийн хөдөлгөөнийг удирдах зэрэг үзүүлэлтүүд харьцангуй доогуур түвшинд хөгжсөн байна. Иймээс оюутны сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааныг дэмжин хөгжүүлэх зайлшгүй шаардлага байгааг харуулж байна.
4. Судалгааны дүнд оюутны сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан болон оюун ухааны хооронд холбоо хамаарал (0.05) байхгүй болох нь тогтоогдсон.

Ном зүй

- Butler, C. a. (2006). Emotional Intelligence and Leadership Behavior in Construction Executives. *Journal of Management in Engineering*, Vol 22, 119-125.
- Chapin, F. (1942). Preliminary standardization of a social impact scale. *American Sociological Review*, 7, 214-225.
- Cherniss, C. (2000). *Emotional Intelligence: What it is and why it matters*. New Orleans, LA.
- Darwin, C. (1872). *The expression of the emotions in man and animals*. Chicago: University of Chicago Press.
- Gardner, H., & Hatch, T. (1989). "Multiple intelligences go to school: Educational implications of the theory of multiple intelligences. *Educational Researcher*. 18 (8).
- Goleman, D. (1995). In *Emotional Intelligence* (pp. 13-14). New York: Bantam.
- Lane, R. Q. (1990). The levels of Emotional Awareness Scale. *Journal of Personality Assessment*, 55, 124-134.
- Mayer, J. (2000a). Spiritual intelligence or spiritual consciousness? *The International Journal for the Psychology of Religion*, vol.10, pp.47-56.
- Mayer, J. D., & Salovey, P. (1997). *What is emotional intelligence?* In I. P. (Eds.), *Emotional development and emotional intelligence: Educational implications* (pp. pp.3 – 31). New York: Basic Books.
- Mayer, J. D., & Salovey, P. (1997). *What is the emotional intelligence?* . In P. & Salovey, *EMotional development and emotional intelligence: Educational implacations* (pp. 3-31). New York: Basic book .
- Neisser, U., Boodoo, G., Bouchard, T. J., Jr., Boykin, A. W., Brody, N., Ceci, S. J. (1996). Intelligence: Knowns and unknowns. *American Psychologist*, Vol 51(2), 77-101.
- Repository, L. U. (2009). *Measuring and enhancing the emotional intelligence of built environment students*. *Yi Yi Mo Thorndike, E. L. (1920)*. Intelligence and its uses. Harper's Magazine.
- Wechsler, D. (1940). *Nonintellective factors in general intelligence*. In D. Wechsler, *Nonintellective factors in general intelligence* (pp. 444-445).

A study on the interrelations between emotional intelligence and intelligence

*Enkhbayar.B^{*a}, Tserendondov.P^b*

^aChief of Pedagogy and Psychology Department, Otgontenger University

^bSchool of educational studeis, Mongolian National University of Education

Abstract

Our research work aims at identifying the relationship between the emotional intelligence and intelligence of the student personality. In doing so, to compare the concepts of scientists on mental and emotional intelligence and students, it studied the emotional intelligence and intelligence and compared the results and relationships. It is incomparable to define successful student learning by the emotional intelligence of intelligence. The study of comparative implications for intelligence and emotional intelligence involvement in mental development is a major factor in successful learning. Observing the findings shows that there is no direct correlation between intelligence and emotional intelligence and it is important to work with students to learn and evaluate both intelligence and emotional intelligence.

Keywords

Self awareness, self regulation, empathy, self motivation, cognitive

* Corresponding author: b.enkhbayar@otgontenger.edu.mn